



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 5/35

Ховд

Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын зайлшгүй шаардлагаар Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагчаар Зоригтбаатарын Батзаяаг 2024 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн төрийн албан хаагчийн тусгай шалгалт зарлагдан, сул орон тоог нөхөгдөх хүртэл хугацаанд түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. З.Батзаяаг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Н.Ганзориг)-д үүрэг болгосугай.

3. З.Батзаяад Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ”-ний ТЗ-7 дахь зэрэглэл буюу 1,320,000 (нэг сая гурван зуун хорин мянга) төгрөгөөр цалинг тооцож, холбогдох нэмэгдлийг олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.САНДАГСҮРЭН

8400003 0193
Tush B/35 Ba